



БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ
ДАХЬ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/258/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
Мөрөн сум
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Бизкон аудит ХХК-ийн
Ахлах аудитор Ч.Мөнхбаяр
Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com

Аудитор: Л.Пунсал-орлом
Утас: 88908680 Цахим хаяг: punsaa73@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.11 № 01/66
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ТӨМӨРСҮХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,721,952.57	148,821,999.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	174,721,952.57	148,821,999.71
351	Түүхий эд материал	124,405,898.74	123,353,888.74
35110	Тусгай зориулалттай материал	124,405,898.74	123,353,888.74
354	Хангамжийн материал	48,958,253.83	24,110,310.97
35410	Бичиг хэргийн материал	4,644,460.83	3,680,877.95
35420	Аж ахуйн материал	37,609,193.00	15,469,333.02
35440	Түлш, шатах тослох материал	6,704,600.00	4,960,100.00
35600	Мал амьтад	1,357,800.00	1,357,800.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	207,783,675.33	239,086,968.69
392	Биет хөрөнгө	131,901,475.33	163,304,768.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	109,037,152.61	116,110,235.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,178,062.42	-22,195,687.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,933,000.00	116,573,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,484,194.56	-48,045,194.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,189,980.00	779,980.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-352,066.65	-509,397.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,345,000.00	7,136,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,589,333.65	-6,544,167.37
393	Биет бус хөрөнгө	75,882,200.00	75,782,200.04
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-99,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	75,682,200.00	75,682,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	382,505,627.90	387,908,968.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	382,505,627.90	387,908,968.40
51	Засгийн газрын хувь оролцоо	382,505,627.90	387,908,968.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	496,989,680.48	496,989,680.48
51101	Өмч: - төрийн	496,989,680.48	496,989,680.48
512	Хуримтлагдсан үр дүн	-194,066,923.49	-181,996,455.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-194,066,923.49	-187,399,795.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	5,403,340.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	79,582,870.91	72,915,743.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	382,505,627.90	387,908,968.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	606,776,267.78	636,455,849.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,090,467.78	94,917,987.00
120	Нийтлэг татварын бус орлого	114,090,467.78	94,917,987.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	114,090,467.78	94,917,987.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,408,545.00	29,150,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,681,922.78	65,767,987.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,685,800.00	541,537,862.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	492,685,800.00	522,426,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	492,685,800.00	522,426,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	19,111,862.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	19,111,862.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	556,272,120.05	631,052,508.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	556,272,120.05	631,052,508.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,787,331.05	589,309,460.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,667,751.00	356,830,428.00
210101	Үндсэн цалин	279,913,700.00	259,590,099.00
210102	Нэмэгдэл	49,099,700.00	83,140,534.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,977,100.00	10,946,515.00
210104	Урамшуулал	4,409,351.00	3,153,280.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,267,900.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,951,162.00	44,640,884.00
210201	Тэтгэврийн даатгал	34,158,570.00	30,900,464.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,914,611.00	3,551,677.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,900,775.00	2,934,832.00
210204	Ажилгүйдлийн даатгал	725,219.00	672,282.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,251,987.00	6,581,629.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,592,100.00	6,561,000.00
210301	Гэрэл, цахилгаан	687,600.00	653,100.00
210302	Түлш, халаалт	6,696,700.00	5,637,700.00
210303	Цэвэр, бохир ус	207,800.00	270,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,112,422.49	39,476,302.88
210401	Бичиг хэрэг	3,403,942.00	4,856,223.88
210402	Тээвэр, шатахуун	27,589,348.49	32,483,879.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,803,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,488,532.00	333,000.00
2105	Нормативт зардал	1,317,600.00	237,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,317,600.00	237,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,284,550.00	46,497,661.00
210604	Урсгал засвар	4,284,550.00	46,497,661.00
2107	Томилолт, зочны зардал	2,536,800.00	2,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,536,800.00	2,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,354,727.51	65,766,990.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,820,403.51	63,728,412.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	516,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	465,700.00	465,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,000.00	222,210.00

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	114,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	325,000.00
210807	Газрын төлбөр	207,624.00	191,468.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,970,218.05	27,261,593.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,970,218.05	27,261,593.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,484,789.00	41,743,048.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,459,600.00	33,108,498.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,459,600.00	7,252,998.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	25,855,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,025,189.00	8,634,550.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,025,189.00	8,634,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	50,504,147.73	5,403,340.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	50,504,147.73	5,403,340.50

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/ төгрөгөөр /	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,989,680.48	69,636,870.91	-244,571,071.22	322,055,480.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,989,680.48	69,636,870.91	-244,571,071.22	322,055,480.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	50,504,147.73	50,504,147.73
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,989,680.48	79,582,870.91	-194,066,923.49	382,505,627.90
D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	496,989,680.48	79,582,870.91	-194,066,923.49	382,505,627.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	6,667,127.66	6,667,127.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,989,680.48	79,582,870.91	-187,399,795.83	389,172,755.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-6,667,127.66	00.00	-6,667,127.66
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,403,340.50	5,403,340.50
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,989,680.48	72,915,743.25	-181,996,455.33	387,908,968.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	550,094,345.00	570,687,862.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,408,545.00	29,150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,408,545.00	29,150,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,408,545.00	29,150,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,408,545.00	29,150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,685,800.00	541,537,862.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	492,685,800.00	522,426,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	492,685,800.00	522,426,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	19,111,862.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	19,111,862.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	550,094,345.00	570,687,862.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,094,345.00	570,687,862.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,609,556.00	528,944,814.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,601,751.00	356,830,428.00
210101	Үндсэн цалин	279,847,700.00	259,590,099.00
210102	Нэмэгдэл	49,099,700.00	83,140,534.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,977,100.00	10,946,515.00
210104	Урамшуулал	4,409,351.00	3,153,280.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,267,900.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,951,162.00	44,640,884.00
210201	Тэтгэврийн даатгал	34,447,088.00	30,814,972.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,626,093.00	3,551,677.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,900,775.00	2,739,097.00
210204	Ажилгүйдлийн даатгал	725,219.00	672,282.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,251,987.00	6,862,856.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,584,000.00	7,276,000.00
210301	Гэрэл, цахилгаан	753,600.00	653,100.00
210302	Түлш, халаалт	6,518,600.00	6,352,700.00
210303	Цэвэр, бохир ус	311,800.00	270,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,457,600.00	18,913,700.00
210401	Бичиг хэрэг	684,000.00	402,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,561,500.00	16,215,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,803,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	581,500.00	492,000.00
2105	Нормативт зардал	407,600.00	237,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	407,600.00	237,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,889,687.00	7,790,524.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,000.00	7,743,024.00
210604	Урсгал засвар	8,687,687.00	47,500.00

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	2,536,800.00	2,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,536,800.00	2,037,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,060,256.00	91,122,078.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,525,932.00	89,083,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	516,000.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	465,700.00	465,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,000.00	222,210.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	114,200.00
210807	Газрын төлбөр	264,000.00	325,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	207,624.00	191,468.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,700.00	96,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,700.00	96,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,484,789.00	41,743,048.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,459,600.00	33,108,498.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	7,252,998.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,025,189.00	8,634,550.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,025,189.00	8,634,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	551,576,000.00	551,576,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	551,576,000.00	551,576,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,720,500.00	517,095,950.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,192,400.00	353,677,148.00
210101	Үндсэн цалин	260,572,500.00	259,590,099.00
210102	Нэмэгдэл	86,642,800.00	83,140,534.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,977,100.00	10,946,515.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,355,900.00	44,246,724.00
210201	Тэтгэврийн даатгал	34,028,300.00	30,586,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,581,900.00	3,514,946.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,865,500.00	2,691,347.00
210204	Ажилгүйдлийн даатгал	716,400.00	664,936.00

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	7,163,800.00	6,789,395.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,276,000.00	7,276,000.00
210301	Гэрэл, цахилгаан	653,100.00	653,100.00
210302	Түлш, халаалт	6,352,700.00	6,352,700.00
210303	Цэвэр, бохир ус	270,200.00	270,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,913,700.00	18,913,700.00
210401	Бичиг хэрэг	402,900.00	402,900.00
210402	Тээвэр, шатахуун	16,215,600.00	16,215,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,803,200.00	1,803,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	492,000.00	492,000.00
2105	Нормативт зардал	237,600.00	237,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	237,600.00	237,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	209,100.00	209,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	161,600.00	161,600.00
210604	Урсгал засвар	47,500.00	47,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,037,000.00	2,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,037,000.00	2,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,402,200.00	90,402,078.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,083,500.00	89,083,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	465,700.00	465,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	222,300.00	222,210.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	114,200.00	114,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	325,000.00
210807	Газрын төлбөр	191,500.00	191,468.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96600.00	96600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,600.00	96,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25855500.00	25855500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,855,500.00	25,855,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,855,500.00	25,855,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	551,576,000.00	551,576,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	522,426,000.00	522,426,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	522,426,000.00	522,426,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	29,150,000.00	29,150,000.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,150,000.00	29,150,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	36.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	24.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	11.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,111,862.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,111,862.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,848,864.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,153,280.00
210104	Урамшуулал	3,153,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	394,160.00
210201	Тэтгэврийн даатгал	228,872.00
210202	Тэтгэмжийн даатгал	36,731.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,750.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,346.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,461.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,581,424.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,581,424.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7252998.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,252,998.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,252,998.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,111,862.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,111,862.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,111,862.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, үнэт цаас, цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Хөвсгөл нуур, Даян дээрхийн дурсгалт газрын онгон байгалиа унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх, хамгаалалтанд авсан газруудыг нутгийн иргэдийг түшиглэн хамгаалах, төрөл бүрийн судалгаа шинжилгээ хийх, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр байгалийн дагалдах баялагийг зүй зохистойгоор ашиглах, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг БОАЖЯ-ны эрхлэх хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БОАЖЯ-ны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/641 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь 2020 оны А/11 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 5 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккреул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 556.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5.4 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	00	00	00
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	174.7	164.7	-10.0
Үндсэн хөрөнгө	207.8	223.2	15.4
Нийт хөрөнгө	382.5	387.9	5.4
Өр төлбөр	00	00	00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	382.5	387.9	5.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	382.5	387.9	5.4

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн А/156 тоот тушаал, БОАЖЯ-ны сайдын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/283 тоот тушаалаар 42.6 сая төгрөгийн үнэтэй УАЗ-220695 маркийн автомашиныг орлого авсан байна. ТӨБЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 584 тоот тогтоолоор тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй байсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн суудлын автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж данснаас хассан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 553.5 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 3.7 сая төгрөгөөр бууруулж 549.8 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллага нь тайлант онд шаардлагатай зардлуудад 1 удаа 1.7 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлсэн зохицуулалт, тодотголыг хийлгэж санхүүжүүлэх эх үүсвэрийг 551.5 сая төгрөг болгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 6 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 551.5 сая төгрөгийн төсөв баталсан ба 522.4 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 29.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 522.4 сая төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 29.1 сая төгрөг, нийт 551.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 542.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 8.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 542.9 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалингийн зардал 98.7 хувийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 91.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал хөтөлбөр	551.5	542.9	8.6	98.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	436.6	428.0	8.6	98.4
80219	Харуул хамгаалалтын зардал	4.5	4.5	00	100
80221	Гэрээт ажиллагсдын зардал	37.3	37.3	00	100
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	25.8	25.8	00	100
81701	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	32.8	32.8	00	100
81703	Ургамал хамгаалах зардал	14.4	14.4	00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 2 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 2021 оны давсан орлого 19.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр урсгал зардлуудад 19.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/

/сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Зөрүү
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал хөтөлбөр	19,111.8	19,111.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	11,848.9	11,848.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	7,262.9	7,262.9

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгаль хамгаалагч нарт олгосон үнэт цаасны тооцоог сар бүр үлдэгдлийг тоолж, тооцоо бодоогүйгээс үнэт цаас дутагдах, үндсэн үйл ажиллагааны орлого шамшигдах магадлал өндөр байна.

3.8 Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 13-2/6661 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэл ба иргэдийн хүсэлтийн дагуу тус байгууллагын 2018-2020 онуудын үйл ажиллагаанд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хийгдсэн хяналт шалгалтаар нийт 11 акт, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Тайлант онд 2 актын 1.1 сая төгрөгийг барагдуулсан байна. Үлдсэн 9 актны 40.1 сая төгрөгийг барагдуулах шаардлагатай байна. Тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргаар ажиллаж байсан Ж.Төмөрсүхийг 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс томилсон боловч Улаан тайгын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргыг томилоогүй учир нэг хүн хоёр тусгай хамгаалалттай газрын даргын үүрэг гүйцэтгэж байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулах мэдээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Шилэн дансанд байршуулах мэдээ

№	Мэдээ гаргах хугацаа	Мэдээний тоо			
		Мэдээлбэл зохих нийт мэдээ	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жилээр гаргах мэдээ	11	9	0	2
2	Хагас жилээр гаргах мэдээ	4	4	0	0
3	Улирал бүр гаргах мэдээ	4	3	1	0
4	Сар бүр гаргах мэдээ	36	27	9	0
5	Тухай бүрт гаргах мэдээ	96	72	24	0
НИЙТ ДҮН:		151	115	34	2

Шилэн дансыг шалгахад тайлант онд мэдээлэх 151 мэдээнээс хуулийн хугацаа болоогүй 2, хугацаандаа мэдээлсэн 115, хугацаа хоцорсон 34 мэдээ байна. Үүнд:

Улирал бүр мэдээлэх “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” оруулах 1 мэдээ, сар бүр мэдээлэх “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”, “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” гэсэн 3 төрлийн мэдээнээс 3,4,5-р саруудын 9 мэдээ, тухай бүр мэдээлэх “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн”, “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”, “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл” гэсэн 8 төрлийн мэдээнээс 3, 4, 5-р саруудын 24 мэдээ, нийт 34 мэдээ хугацаа хоцорч шилэн дансанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 34 мэдээ хугацаа хоцорч байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 496.9 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 496.9 сая төгрөгтэй таарч байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол улсын УИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгалыг хадгалах, ховордсон ургамал, амьтныг хамгаалах зорилгоор түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий зарим газар нутгийг доор дурдсан ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан байна. Уг тогтоолын 2-т зааснаар Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох сумд, Завхан аймгийн Тэлмэн, Их-Уул сумдын нутгийг дамнан орших Тэсийн гол, Булнайн нурууны 369,630.89 га газрыг байгалийн цогцолборт газраар бүртгэж авсан байна. Гэвч байгаль хамгаалагчийн зардлын төсвийг Засгийн газраас батлаагүй байна.

Тайлант онд Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын байгаль хамгаалагчаар Н.Нямбаяр, Д.Базар, Б.Гүндсамба нарыг 2020 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Б/47, Б/48, Б/49 тоот тушаалаар, Д.Найдансүрэн, Х.Баасандорж нарыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/93, Б/94 тушаалаар тус тус томилсон бөгөөд эдгээр байгаль хамгаалагч нарын цалингийн зардалд нийт 25.8 сая төгрөгийг Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанаас цалингийн сандаа багтаан цалинжуулснаас болж батлагдсан бүтэц, орон тоогоороо ажиллаж чадаагүй байна. Цаашид Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын урсгал зардлыг баталж өгөхгүй бол тус байгууллага нь өөрийн хариуцах газарт ажиллах байгаль хамгаалагч, хүн хүч хүрэлцэхгүй үйл ажиллагаа доголдох магадлал өндөр байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.2 сая төгрөгийн алдаа залруулж, 4.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант оны 0,15 сая төгрөгийн интернетийн төлбөрийг бичиг хэргийн зардалд, 0.15 сая төгрөгийн шатахууны зардлыг тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардалд бүртгэснийг тус тус залруулав.
2. Тайлант онд ашиглалтанд орсон 15.9 сая төгрөгийн өртөгтэй Цагаан-Үүрийн хэсгийн байрыг бараа материал дансанд бүртгэснийг үндсэн хөрөнгө дансанд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Цалингийн зардалтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 1.3 сая төгрөгийг цалингийн зардал руу зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2."Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж байх.

2. **Цалингийн зардалтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд ажлаас чөлөөглөгдсөн ч шүүхийн захирамжаар ажилдаа эргэн томилогдсон ажилтанд ажилгүй байсан үеийн цалин 3.5 сая төгрөгийг цалингийн сангаас олгосон байгууллагын хохирлыг буруутай албан тушаалтнаар барагдуулаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хуулийн дагуу буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжээр шийдвэр гаргуулж байгууллагыг хохиролгүй болгох.

3. **Үнэт цаастай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Байгаль хамгаалагч нарт олгосон үнэт цаасны үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоо бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Сар бүрийн эцэст үнэт цаасны үлдэгдлийг тоолж, тооцоог бодож үйл ажиллагааны орлоготой тулгаж хэвшүүлэх

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл байршуулсан дүнг хянаж үзэхэд нийт хугацаа хоцорсон 34 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн хугацаанд шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



/Э.БАТ-ЭРДЭНЭ/

2022.02.10

Огноо:

АХЛАХ АУДИТОР



/Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР



/Ч.МӨНХБАЯР/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР



/Л.ПУНСАЛ-ОРЛОМ/

Огноо: 2022.02.10.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		6	21.0	2	16.2	0	0	0	0	4	4.8